



147 Page



148 Page



149 Page

Ханна ба Самуел

-Hannah and Samuel-

Тайлбарлагч Израильд Елкана гэдэг нэртэй хүн байжээ. Елкана хоёр эхнэртэй байсан бөгөөд нэгнийх нь нэр Ханна, нөгөөгийнх нь нэр Пенинна гэдэг байжээ. Пенинна олон хүүхэдтэй, Ханна нь хүүхэдгүй байв. Харин Елкана Ханнадаа илүү хайртай байлаа. Үүнийг мэдсэн Пенинна уурлан, Ханнаг үргэлж зовоодог байжээ.

Пенинна Хүүхэд гаргаж чаддаггүй тэнэг эмэгтэй!
Тайлбарлагч Ханна хүүхэдгүйгээсээ болж сэтгэл нь урагдах мэт өвддөг байлаа. Тэр ихэд гуниглан уйлж, хоол ч идэж чадахгүй байлаа. Нөхөр нь түүнийг хичнээн аргадсан ч Ханнагийн сэтгэл тайвшрахгүй байв.

Тайлбарлагч Ханна сүмд очин, Бурханы өмнө уйлан залбирчээ.
Ханна Бурхан минь, надад хүү хайрлаач. Тэгвэл би тэр хүүг амьдралынх нь бүх өдөрүүдэд Танд өргөө.

Тайлбарлагч Ханна маш удаан хугацаанд Бурханд залбирчээ. Энэ үед тахилч Ели сүмд орж ирэв. Ханна маш удаан залбирсанаас болж дуу нь ч гарахгүй зөвхөн уруул нь л хөдөлж байлаа. Ели түүнийг дарсанд согтсон гэж боджээ.

Ели Хэдий болтол согтуу байх юм бэ? Дарснаасаа сал!
Ханна Тахилч минь, би дарсанд согтоогүй. Харин сүнс минь маш их шаналж байна. Тэгээд Бурханд залбирч байна.

Тайлбарлагч Ханнагийн яриаг сонсоод Ели түүнийг ерөөлөө.
Ели Амар амгалан явагтун! Израилийн Бурхан чиний гуйсан гуйлтыг биелүүлэх болтугай!

Тайлбарлагч Ханна маш их талархжээ. Тэгээд хоол унд идэж, дахин санаа зовохоо больжээ.

Тайлбарлагч Бурхан Ханнагийн залбирлыг сонсож, түүнийг хүүтэй болгожээ. Ханна хүүгээ төрүүлээд, түүнийг Самуел гэж нэрлэв. Хүүгээ хөхнөөс нь гарах хүртэл өөр дээрээ хайрлан өсгөжээ. Самуелыг хөхнөөс нь гармагц, Бурханд амласнаараа түүнийг сүмд авчиржээ.

Ханна Тахилч минь, би энд ирээд залбирч байсан эмэгтэй байна. Бурханаас хүүхэдтэй болохыг хүсэн залбирахад, Бурхан гуйлтыг минь сонсож хүү өгсөн. Би амласныхаа дагуу хүүгээ Бурханы сүмд авчирлаа.

Тайлбарлагч Ханна баяртайгаар Бурханыг магтан дуулжээ.



150 Page



151 Page



152 Page



153 Page



154 Page



155 Page

Тайлбарлагч Бяцхан Самуел тахилч Елитэй хамт Бурханд үйлчлэн сүмд амьдрах болжээ. Бурханы ивээлээр Ханна гурван хүү хоёр охинтой болжээ.

Тайлбарлагч Самуел өсөн том болж, өдөр бүр Бурхантай хамт байхдаа дуртай байлаа. Бурханы дэнлүү хараахан унтраагүй үед, Бурханы авдар орших Эзэний сүмд Самуел хэвтэж байв. Эзэн Самуелийг дуудах дуу хоолой сонсогдов.

Бурхан Самуел! Самуел!

Тайлбарлагч Самуел маш хурдан босож, Ели тахилч дээр очжээ.

Самуел Та намайг дуудсан тул би энд байна.

Ели Би чамайг дуудаагүй. Буцаж яваад хэвтэгтүн!

Тайлбарлагч Самуел дахин сүм уруу ортол

Бурхан Самуел! Самуел!

Тайлбарлагч Самуел! гэж дуудахыг дахин сонсжээ. Самуел хурдлан явсаар Ели тахилч дээр иржээ.

Самуел Та намайг дуудсан тул би энд байна.

Ели Үгүй, хүү минь! Би чамайг дуудаагүй. Буцаад хэвтэхтүн!

Тайлбарлагч Самуел дахин сүм уруу ирэх үед

Бурхан Самуел! Самуел!

Тайлбарлагч Дахин түүнийг дуудах дууг сонсжээ.

Самуел Ели тахилчаа намайг...ёооё Би саяхан унтсан шдээ

Тайлбарлагч Самуелыг Бурхан дуудсан болохыг Ели ойлгожээ.

Ели (Хоолойгоо засаад) Хмхм.. Самуел! Бурхан чамайг дууджээ. Хурдан очоод "Бурхан минь, айлдаж хайрла, боол тань сонсож байна" гэж хэл!

Тайлбарлагч Самуел сүм уруу орж ирээд дахин өөрийг нь дуудахыг сонсов.

Бурхан "Самуел! Самуел!"

Самуел Бурхан минь, айлдаж хайрла. Боол тань сонсож байна!

Тайлбарлагч Энэ үеэс эхлэн Бурхан Самуелтай ярилцдаг болжээ. Самуелыг өсөж том болох цаг мөч бүрд Бурхан түүнтэй хамт байв. Ийнхүү бүх Израиль Самуелыг Эзэний эш үзүүлэгч мөн болохыг мэдэв.

Тайлбарлагч Самуел Бурханы үгийг сонсоод ард түмэнд дамжуулдаг байлаа. Самуел олон жилийн турш Бурханд үйлчлэн амьдарчээ. Тэрээр Бурханы үгээр ард олныг удирдаж байсан төдийгүй Израилийн хаадыг тосолжээ. Самуел бол ард түмэнд Бурханы үгийг зааж, дамжуулдаг агуу хүн байлаа.